



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР**



Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ



2023 оны 3 дугаар сарын байдлаар

Мөрөн сум

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 3 сарын байдлаар 552 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 34 тохиолдол буюу 6.6%-иар буурсан байна. Төрөлт Рэнчинлхүмбэ, Тосонцэнгэл, Ханх, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Цагааннуур сумдад өсч бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрсөн эхчүүдээс 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хамрагдалтын хувь 75,5% байна.



ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 3 сарын байдлаар нийт 553 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 35 тохиолдолоор өссөн байна. Амьд төрсөн хүүхдийн 2,2 хувь /12/ нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн байна. Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 98,4 хувь байна. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 2023 оны эхний 3 сард нийт 12494 хүүхэд жинлэж, жинлэсэн хүүхдийн 0.1 хувь нь туранхай, 0,1 хувь нь тураалтай, 0,2 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 0.8 хувь нь А амин дэм, 66.9 хувь нь Д амин дэм, 4.2 хувь нь олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн байна.

НЯЛХАСЫН ЭНДЭГДЭЛ

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 3 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 8 тохиолдол бүртгэгдсэн нь 2022 оны мөн үеэс 2 тохиолдлоор өсч, 1000 амьд төрөлтөнд 14.5 ногдож байна. Нялхсын эндэгдлийн 37.5 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд 5.4 байна. Нийт 4 тохиолдол буюу 50.0 хувь нь эмнэлэгт эндсэн бөгөөд 4 нь эрэгтэй хүүхэд байна.

Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:



1-5 НАС ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2023 оны эхний 3 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 3 тохиолдлоор буурсан байна. 1000 амьд төрөлтөнд 7,2 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны эмгэг 1, амьсгалын тогтолцооны эмгэг 1, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 2 тохиолдол бүртгэгдсэн байна.



НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны эхний 3 сарын байдлаар 190 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 4 тохиолдолоор өссөн байна. Нийт нас баралтын 22,1 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 35,7 хувь нь хоног болоогүй нас баралт байна. Осол гэмтлийн нас баралт 19 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 5 тохиолдолоор буурсан, нийт нас баралтын 10,0 хувийг эзэлж, 10000 хүн амд 1,4 ногдож байна. Хорт хавдрын нас баралт 51 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 6 тохиолдлоор өсч, нийт нас баралтын 26,8 хувийг эзэлж, 10000 хүн амд 3,7 ногдож байна.



Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/



1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 6.0
2. Хавдар-3.7
3. Гадны шалтгаант өвчлөл- 1.4
4. Амьсгалын тогтолцооны өвчин-0.8
5. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-0.7



Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 3 сарын байдлаар нийт эдийн шинжилгээ 334, эсийн шинжилгээ 880 хийгдсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 31 нас баралт буюу 54.8% эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдэж үндсэн оношийн зөрүү бүртгэгдээгүй байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 17 тохиолдол байна.

АМБУЛАТОРИ СТАЦИОНАРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ


Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 3 сарын байдлаар амбулаторид нийт 128445 үзлэг хийгдсэнээс 25.0 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 62.9 хувийг өвчний учир амбулаторид, 5.6 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 4.1 хувийг гэрийн идэвхитэй үзлэг, 2.4 хувийг гэрийн дуудлагын үзлэг эзэлж байна.



ЖИРЭМСЭНИЙ ХЯНАЛТ

Шинээр хяналтанд авсан нийт 551 жирэмсэн эмэгтэйчүүдээс 93.8 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтанд хамрагдсан байна. Цусны шинжилгээнд 98.2 хувь нь хамрагдаж, 1.5 хувь нь цус багатай гарсан байна. Эхний 3 сарын байдлаар жирэмсний хяналтанд шинээр орсон эхчүүдээс трихомониаз, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 94.9 хувийг, тэмбүү болон ХДХВ илрүүлэх шинжилгээнд 96,2 хувийг тус тус хамруулж заг хүйтэн-8, трихомониаз-2, тэмбүү-7 тохиолдлыг тус тус бүртгэн эмчилсэн байна.

Жирэмсэний эрт хяналтын хувь,
2023 оны эхний 3 сарын байдлаар



ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2023 оны эхний 3 сарын байдлаар халдварт бус өвчлөл 47388 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 18461 тохиолдлоор буурсан байна. 10000 хүн амд 3438,9 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 427 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 0,9 хувийг эзэлж, 10000 хүн амд 31,0 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 830.3
2. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-689.0
3. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 655.3
4. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-383.6
5. Мэдрэлийн тогтолцооны өвчин-280.6


Стационарт нийт 8101 хүн хэвтэж эмчлүүлсэн ба дундаж ор хоног 6,7, орны эргэлт 8,1, орны фонд ашиглалт 54,6 фонд ашиглалтын хувь 66,1 байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 3 сарын байдлаар нийт 5571 түргэн тусламжийн дуудлага хүлээж авч гүйцэтгэсэнээс 16,4 хувь /914/ нь алсын дуудлага, 3,4 хувь /189/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 61,9 дуудлага, АНЭ 22,6 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.


ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны эхний 3 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 5788 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 6,6 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 64,3% эрэгтэй, 35,7% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 1252 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон артерийн гипертензи 233 буюу 18,6% нь онош баталгаажсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 4893 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 9,4 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 36,6% эрэгтэй, 63,4% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 43 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон 2 буюу 4,7% нь онош баталгаажсан байна.


Эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр



Эрт илрүүлэг үзлэг, нэгжээр



Эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр



ӨРХИЙН ЭМТ-ИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 18024 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 32.8 хувь
- Өвчний учир үзлэг 42.0 хувь
- Диспансерийн хяналт 13.3 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 10.9 хувь
- Гэрийн дуудлага 1.0 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 6422 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 5.4 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.2 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 214 жирэмсэн эмэгтэйгээс 91.1 хувийг эрт үед нь хяналтанд авч 100 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 66 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 17 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 21, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 7 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн нэгдсэн эмнэлэгт 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хувийн эмнэлгүүд нийт 9118 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 13.9 хувь
- Диспансерийн хяналт 2.6 хувь
- Өвчний учир үзлэг 83.5 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 2253 хүн хэвтэн эмчлэгдэж, 16362 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.3 орны эргэлт 7.4 ба орны фонд ашиглалт 54.0, орны фонд ашиглалтын хувь 65.5 байна. Нийт халдварт бус өвчний 9 тохиолдлоос 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 8 тохиолдол бүртгэгдсэн байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН

Аймгийн хэмжээнд эхний 3 сарын байдлаар 271 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 19,7 ногдож байна. 2022 оны мөн үед 3614 тохиолдол, 10000 хүн амд 264,1 ногдож байжээ. 10000 хүн амд ногдох халдварт өвчний гаралт Алаг-Эрдэнэ, Арбулаг, Бүрэнтогтох, Төмөрбулаг, Түнэл, Цагаан-Үүр, Цагааннуур, Мөрөн суманд аймгийн дунджаас өндөр байна.

Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 74,5 хувь, сүрьеэ 4,4 хувь, амьсгалын замын өвчин 13,0 хувь, цусан халдвар 1,5 хувь, гэдэсний халдварт өвчин 5,5, арьс салтстаар халдварлах халдвар 0.7, Ковид-19 халдвар 0,4 хувийг тус тус эзэлж байна.

ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт цочмог халдварт өвчний 69 тохиолдлоос:

- Сүрьеэ 12 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Ковид-19 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3269 тохиолдлоор тус тус буурч
- Сальмонеллэз 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Цусан суулга 13 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 11 тохиолдлоор
- Хоолны хордлого 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит С 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор

- Салхинцэцэг 27 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 12 тохиолдлоор
- Гар хөл амны өвчин 8 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 8 тохиолдлоор тус тус өссөн
- Хепатит В болон Ёлом тус тус 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үетэй адил байна.
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.




ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ


1. 2023 оны эхний 3 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 54 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс халууралт тууралт 7.4 хувь (4), цэврүүт тууралт 59.3 хувь (32), цочмог халууралт, цусархаг тууралтат 13.0 хувь (7), шарлалттай 7,4 (4), хоолны хордлогот халдвар 1,9 хувь (1) тус тус бүртгэгдсэн байна.
2. Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/




Халдварт өвчний хамшинж, сэжигтэй нийт тохиолдол, бүртгэгдсэн долоо хоногоор



Халдварт өвчний хамшинж сэжигтэй өвөрмөц тохиолдол бүтцээр, 13-р долоо хоногийн байдлаар




Тууралттай хамшинжийн тохиолдол мэдээлэгдсэн долоо хоногоор




ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН

2023 оны эхний 3 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 8892 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 649,8 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 9583 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 714,5 болсон байна.


Томуу, томуу төст өвчин, 10 000 хүн амд




Томуу томуу төст өвчин, долоо хоног



Томуу, томуу төст өвчин (насны бүлэг, хувиар)





АЗЦХХ-ын хэвтэлт (насны бүлэг, хувиар)



БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний эзлэх хувь 74,5% (202) тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 8,5% (307) тохиолдол бүртгэгдсэнээс:

- Гонококкт халдвар 150 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 103 тохиолдлоор
- Трихомониаз 8 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 11 тохиолдлоор тус тус буурч
- Тэмбүү 44 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор өссөн байна.



ЗӨВЛӨМЖ:

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА М.ЭНХДАЛАЙ

Жирэмсний хяналт 2023 оны эхний 1 дүгээр улирлын байдлаар жирэмсний хяналтад 551 эх, үүнээс 517 эх эрт хяналтад орсон, эрт хяналт 93.8%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.8%-иар өссөн эерэг үзүүлэлттэй байна. Жирэмсний эрт хяналт Баянзүрх (91.7%), Бүрэнтогтох (85.7%), Рэнчинлхүмбэ (87%), Төмөрбулаг (90.7%), Түнэл (92%), Эрдэнэбулган (81%) ЭМТ-үүд аймгийн дундажаас доогуур үзүүлэлттэй байна.

Гэрийн төрөлт: 2023 оны эхний 3 сарын байдлаар гэрийн төрөлт 2 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1-оор буурсан. Үүнд: Мөрөн сумын Энх-Үйлс ӨЭМТ-ийн хяналтад байсан 2 эх гэртээ төрсөн.

Амьгүй төрөлт: 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 2, өмнөх оны мөн үеэс 1-ээр буурсан Нэгдсэн эмнэлэгт 1, Шинэ-Идэр суманд 1 эх төрсөн. Гурван гал ӨЭМТ-ийн хяналтад жирэмсний хожуу хордлогын хүнд хэлбэртэй эхийг багийн эмчийн хяналтад шилжүүлж эхсийн дутмагшил, эхэс бүрэн хорвхролтын улмаас амьгүй болсон. Эхийн өвчлөлийн байдлаар авч бүгд эрхтэн тогтолцооны эмгэгтэй, бөөр шээсний замын эмгэг, артерийн даралт ихсэлт, хожуу хордлогын хүнд хэлбэрийн улмаас хэвийн байрласан эхэс цагаас өмнө ховхорч их хэмжээний цус алдалтын улмаас ураг эх дотроо амьгүй болсон байна.

Нярайн эндэгдэл 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 3 тохиолдол бүртгэгдсэн, өмнөх оны мөн үеэс 1 тохиолдолоор буурсан. Эхийн насаар нь авч үзвэл 20-35 насны эхчүүд, тээлтийн хугацаагаар гүйцэд 2 нярай, 34 долоо хоногтой төрсөн 1 нярай энджээ. Эхийн эрүүл мэндийн хувьд 3 эх бөөр шээсний замын эмгэгтэй, 2 эх хожуу хордлогын хүнд хэлбэртэй байсан. Нас баралтын шалтгаан нь тархины цусан хангамжийн хямралын улмаас 2, төрөх үеийн хүнд бүтэлтийн улмаас 1 нярай эндсэн.

Төрөлхийн хөгжлийн гажиг нийт 6 тохиолдол бүртгэгдсэн, эхийн насаар нь авч үзвэл 20-оос доош насны 1 эх, 20-35 насны 5 эх байна. Гажгийн хэлбэрээр авч үзвэл зүрхний төрөлхийн гажиг 3, бусад жижиг гажиг 3. Ургийн гажиг хөгжлөөс сэргийлэх зорилгоор жирэмсэн эхчүүдэд фолийн хүчил уухыг зөвлөж байгаа боловч фолийн хүчлийг огт хэрэглээгүй (40%), тогтмол бус (40%), тогтмол уусан (20%) байна. Төрөлхийн хөгжлийн гажиг оношлогдсон хугацаагаар нь: дээрх 6 тохиолдол нь жирэмсний тээлтийн хугацаанд оношлогдоогүй, бүгд төрөх үед, төрсний дараах эхний 7 хоногтойд оношлогдсон байна.

Эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр өгөх зөвлөмж:

1. Аймгийн Засаг даргын албан даалгавар, Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 70, 71, 72, 73 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангаж зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган эхийн хүндрэл, эндэгдлээс сэргийлж ажиллах

2. Жирэмсний хяналтын хугацаанд эрсдлийн үнэлгээг заасан хугацаанд бүрэн хийж хэвших, өмнөх төрөлтийн талаар мэдээлийг бүрэн авч эрсдлийг илрүүлэх, ЭМС-ын 2020 оны 318 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах, жирэмсний хяналтын “ЭЭЖ” программын ашиглалтыг сайжруулах, хяналтын чанарт сум, өрхийн ЭМТ-ийн дарга нар үнэлгээ хийх, их эмч нарын оролцоог нэмэгдүүлэх

3. Эхийн үзлэгийг бүрэн хийж эрсдэлт хүчин зүйл, эрхтэн тогтолцооны эмгэгийг илрүүлэх, шаардлагатай тохиолдолд шатлалын тусламжид илгээн эргэх холбоотой ажиллах

4. Эх барихын болон яаралтай тусламжийн бэлэн байдлыг ханган ажиллаж эхийн өвчлөл, хүндрэлийн үед мэргэжлийн эмчя нараас зөвлөгөө авах, хүндрэлийн талаар Эрүүл мэндийн газарт мэдээлэл хүргүүлэх

5. Жирэмсэн эх бүрийг товлот үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулах, үзлэгээр илэрсэн эмгэг өөрчлөлтийг үнэлэх, жирэмсний хяналтын төлөвлөгөөг боловсруулж шаардлагатай тохиолдолд СЭМТ-ийн эмч нарын хамтарсан үзлэг хийж хүндрэлийг шийдвэрлэх

6. Нийгмийн эмзэг бүлгийн болон өндөр өртөмтгий эх, хүүхдийн хяналтыг сайжруулах, эрсдлийн үнэлгээ хийж эрсдлийг бууруулах чиглэлээр сум орон нутаг, эрүүл мэндийн салбар зөвлөлийн оролцоотой асуудлыг шийдвэрлэн хүндрэлээс сэргийлж ажиллах

7. Амьгүй болон дутуу төрөлтөөс сэргийлэх зорилгоор эхийн үрэвсэлт өвчнүүдийг эрт илрүүлж эмчилж хяналтад авах, эмчилгээний үр дүнг тухай бүр хянах шаардлагатай. Үүнд бөөр шээсний замын үрэвсэл, бэлгийн замын үрэвсэлт өвчин, бэлгийн халдварт өвчнүүдийн илрүүлэг, эмчилж эрүүлжүүлж хяналтад авах

8. Ургийн гаж хөгжил нь нярайн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан болсоор байгааг шат шатандаа анхаарч 10-12 долоо хоногтойд өндөр эрсдэлтэй жирэмсэн эх, 18-21 долоо хоногтойд ургийн гажиг илрүүлэх зорилгоор жирэмсэн эх бүрийг хоёрдугаар шатлалд шилжүүлэхийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд хэрэгжүүлж ажиллах, жирэмсэн эхчүүдэд фолийн хүчлийг тогтмол уулгаж хэвшүүлэх, олон найрлагат бичил тэжээлийн хэрэглээг нэмэгдүүлэх

9. СЭМТ, ӨЭМТ-ийн бүх ажилтнуудад эх, хүүхдийн тусламж үйлчилгээтэй холбоотой тушаал журмын эмхэтгэл, файл үүсгэн, нийтийн уншлага зохион байгуулах, мэдээлэл хийх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах /ЭМС-ын 2017 оны 207, 2018 оны 305 дугаар тушаал “Эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бүртгэх мэдээлэх журам”, ЭМС-ын 2020 оны 318 дугаар тушаал “Жирэмсэн, төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчлэгээний журам”/

10. Жирэмсэн эхийн шилжилт хөдөлгөөнийг эх баригч, эмч нар гараас гарт шилжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, эхийг хүлээн авсан эрүүл мэндийн байгууллага анхны үзлэгийг хийж хүлээгдэх эрсдэл хүндрэлийг тооцох, багийн эмч нар хариуцсан нутаг дэвсгэрт өөр аймаг, сумаас ирсэн эх болон бага насны хүүхдийн мэдээлэлийг СЭМТ-ийн даргад тухай бүр мэдэгдэж байх

13. Хөдөө орон нутгийн эхчүүд мал төллөх, ноолуур самнах зэрэг цаг үеийн ажил, хаврын улирлын онцлогтой холбоотой биеийн дархлаа сулрах, жирэмсэн эхийн эрхтэн тогтолцооны эмгэг, архаг суурь өвчин сэдрэл үүсэх эрсдэлтэй тул эхэд хүндрэлээс сэргийлэх зөвлөмж, мэдээлэлийг мессэж үйлчилгээгээ болон сургалтын бүх хэлбэрээр хүргүүлэх, сум орон нутаг, багийн Засаг дарга нартай хамтарч эрсдэлт бүлгийн эхчүүдийг хүндрэлээс сэргийлэх

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ш.АЛТАНТУЯА

2023 оны эхний улирлын байдлаар 0-5 насны хүүхдийн эндэгдлийн 12 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор нэмэгдсэн байна. Харьяаллаар авч үзвэл Тариалан, Далайн-Элбэрэлт, Дэлгэрмөрөн, Энэрэл тус бүр 2, Цагааннуур, Ренчинлхүмбэ, Түнэл, Энх-Үйлс тус бүр 1 байна. Үүнээс гэрийн эндэгдэл 6 тохиолдол бүртгэгдсэнээс: Энэрэл 2, Дэлгэрмөрөн / Орхон аймгийн харьяат/, Тариалан, Далайн-Элбэрэлт / Үндсэн харьяалал Шинэ-Идэр сум/, Гурвангал тус бүр 1 тохиолдол гарсан байна. Мөн хоног болоогүй эндэгдэл Тариалан сумаас гарсан ба Цагааннуур сумаас тээвэрлэж яваад замдаа эндсэн тохиолдол бүртгэгдлээ. 12 тохиолдлын 7 буюу 58,3 хувь нь уушигны хатгалгаа өвчнөөр ДЭМБ-ын тодорхойлолтоор сэргийлж болох нас баралтаар эндсэн нь анхаарал татаж байна. Иймээс дараах зөвлөмжийг ажил үйлчилгээндээ хэрэгжүүлж ажиллах. Үүнд:

1. Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан эх, хүүхдийн чиглэлээр хийх ажлын чиглэлийг хүргүүлсэн ба хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, эзэнжүүлэн хэрэгжилтийг тооцож ажиллах.

2. Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/206 тоот албан бичгээр тээвэрлэлтийн болон лавлагаа эрүүл мэндийн байгууллагаас зөвлөгөө авах журмын төслийг хүргүүлсэн тул өөрийн нөхцөл байдалд тохируулан журам гаргаж батлуулан хэрэгжүүлж, хяналт тавих.

3. Эрүүл мэндийн төвийн чанарын үндсэн үзүүлэлтүүдийг гаргаж сар, улирал, хагас жил, жилээр харьцуулсан үнэлгээ хийж холбогдох сумын удирдлагуудыг мэдээллээр хангах.

4. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл, эмнэлэг хооронд өвчтөн шийлжүүлэх асуудлыг чирэгдэлгүй, аюулгүй, шуурхай зохион байгуулах, ялангуяа бага насны

хүүхэд, эмнэлэгт хандсан тохиолдолд харьяалал харгалзахгүй эмнэлгийн яаралтай тусламжийг хугацаа алдалгүй, шуурхай үзүүлэх, эмнэлэг хооронд чирэгдүүлэхгүй байх.

5. Эрүүл мэндийн сайдын баталсан тушаал, журам, зааврын дагуу тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх, бодит үзлэгийн бүрэн гүйцэд хийх.

6. Амилуулах суурь болон л гүнзгийрүүлсэн тусламж, хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламжийн чиглэлээр эмнэлгийн эмч, мэргэжилтэнд мэдлэг олгох, ур чавдар эзэмшүүлэх, ажлын байрны дагалдан сургалтад хамруулах, үр дүнг тооцох.

7. 0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн явцыг эрчимжүүлэх, үзлэгээр илрсэн өвчлөлийг хяналтанд авч эрүүлжүүлэх арга хэмжээ авах.

Сэргийлж болох 6 тохиолдлын кейсийг хүргүүлээ. Сургалтандаа ашиглаж ажиллана уу.

1.19 настай эхийн анхны хүүхэд. 27 хоногтойдоо гэртээ эндсэн. Шүүхийн шинжээч эмч: Амьсгал бүтэлт эхийн хөхөөр дарагдалт гэсэн дүгнэлт гарсан. Жирэмслэлт төрөлт хэвийн явагдсан, Хүүхэд хугацаандаа Апгарын 7/8 оноотой төрсөн. Өрхийн эмнэлэг 3 удаа идэвхитэй эргэлт хийсэн. Үүнээс бид сэргийлж чадах уу? /2022 оны 12 сарын тохиолдол/

2. Нэгэн сумын эмнэлэгт 9 хоног Уушгины хатгалгаар эмчлэгдсэн 1н1 сартай хүүхэд Дауны шинж тэмдэгтэй. Зүрх хоорондын таславчийн цоорхойтой гэсэн хавсарсан оноштой. Лавлагаа шатлалын эмнэлэгт ирээд хоног болоогүй эндсэн. Бид нар яах байсан бэ?

3. 2 сар 27 хоногтой 2 ихэр хүүхдийн 2 дах хүүхэд. Дутуу төрөлтөөр төрсөн. Сумын эмнэлэгт Уушгины хатгалгаа өвчнөөр 7 хоног эмчлэгдээд биеийн байдал сайжрахгүй байсан ба 7 дахь хоногт тээвэрлэж замд нас барсан. Ийм тохиолдолд ямар арга хэмжээ авах байсан болон бид нарын алдаа хаана байсан бэ?

4. Нэгэн сумын үндсэн харьяалалтай хүүхэд. 1н 5 сартай жи нь 4,5 кг. Эцэг эхийн асаргаа сувилгаа маш муу. Хүүхэд харааны бэршээлтэй. Хоол тэжээлийн бэршээлтэй. Хатгалгаа өвчнөөр хэвтэж эмчлэгдэж байгаад гарсан. Сумын ЭМТ-ийн эмчийн хяналтанд маш хангалтгүй үзүүлж байсан. Сум, өрхийн хооронд явдаг. Гадуур хатгалгааны эмчилгээ заалгаж хийлгэж байсан боловч гэртээ эндсэн. Энэ хүүхдэд ямар арга хэмжээ авах байсан бэ?

5. Нэгэн сумын эмнэлэгт 7 сар 11 хоногтой хүүхэд уушгины хатгалгаа өвчнөөр хэвтэж эмчлэгдэж байгаад гарсан. 35 настай эхийн 3 дахь хүүхэд. 9 жилийн дараа төрсөн. Жирэмслэлт төрөлт хэвийн явагдсан. Амралтын өдрүүдэд эмч нь үзээгүй мөртлөө хүүхдийг сайжирсан гээд гаргасан боловч хүүхэд 14 цагийн дараа хүүхдийн биеийн байдал муудаж дуудлага өгсөн. Эмнэлгээс гарсан оройдоо халуурч дуудлага өгсөн боловч дуудлагын эмч өндөр халууралттай хүүхдийг үзээд гэрт орхисон. Эмнэлгээс гарснаас хойш 24 цагийн дараа өглөө нь нас барсан байдалтай өглөө эмнэлэг дээр эцэг эх нь тэвэрч ирсэн. Энэ тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ? Бид нарын алдаа хаана байна вэ?

6. Түр оршин суугч 6 сартай хүүхэд нэгэн эмнэлэгт 2 хоног уушгины хатгалгаагаар эмчлэгдэж байгаад ээж нь эмчилгээний 2 дахь хоногт эмчилгээнээс татгалзаж 1 сарын 24-нд гарсан. Гараад хүүхдээ эгч дээрээ орхиж явсан 1 сарын 29-нд дүгнэлт ирүүлсэн. Эмчилгээний түүхийг татаж харахад 1 сарын 30 хүртэл тэмдэглэсэн.

Биеийн байдал сайжирсан гээд эмнэлгээс гаргасан. Энэ тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ? Ямар алдаа байсан бэ? .Эмчилгээ, үйлчилгээний ямар дутагдал байсан бэ?

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ХОРОЛСҮРЭН

2023 оны 1-р улиралд БЗДХ-ын эрт илрүүлэг үзлэгт 16-65 насны 8311 иргэнийг хамруулсан нь хамрагдах хүн амын 9.6 хувьд хүрч Илэрсэн заг хүйтэн, трихомониаз өвчин бүрэн эмчлэгдэж, тэмбүү өвчний 95 хувь нь бүрэн тун эмчилгээнд хамрагдаж 2.4 хувь нь эмчлэгдэх шатандаа байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн 97.4 хувийг ХДХВ/тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамруулсан байна.

ЗӨВЛӨМЖ:

- Илрүүлэг үзлэгийн хамралтын хүртээмж чанарыг нэмэгдүүлэн ажиллах
- Уг өвчнөөс сэргийлэх аргуудыг сурталчлан, дадал хэвшил болгох
- Тохиолдлын бэлгийн хавьтал бүрт бэлгэвч хэрэглэх зан үйлийг төлөвшүүлэх
- Илэрсэн тэмбүү өвчнийг бүрэн эрүүлжүүлэх, тэдгээрийн хавьтал судлах ажлын чанарыг сайжруулах
- Жирэмсэн эмэгтэйчүүдийг шинжилгээнд товллын дагуу бүрэн хамруулах
- Нэг цэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх
- Иргэдэд чиглэсэн нэр хаяггүй, нууцлал хадгалсан зөвлөгөө өгөх / өөрийгөө хамгаалах зөв зан үйл төлөвшүүлэх, хэрэв халдвар авсан бол цаг алдалгүй, бусдад халдвар тараалгүй мэргэжлийн эмч нарт хандах, гэр бүл төлөвлөх шийдвэр гаргасан бол эмчид БЗДХ-тай эсэхийг заавал үзүүлж хэвших, жилд 2-оос доошгүй удаа эмчийн үзлэгт орж эрүүл эсэхээ нягталж байх зэрэг чадвар"-ыг эзэмшүүлэх
- Нийтэд чиглэсэн ухуулга нөлөөллийн баг бүрдүүлж иргэд залуучуудын оролцоотой зохион байгуулж нийтийн хүртээл болгон цаг үеийн нөхцөл байдалаас болж хойшлуулахгүй тогтмол ажиллах
- Тайлан мэдээг сар бүрийн сүүлийн өдөр ирүүлж хэвшиж байгаа боловч, зарим тохиолдолд 1-2 хоногоор хойно ирүүлж байгаад дүгнэлт хийж, тоон тайлангийн хамт тухайн сард явуулсан МСС-ны бичмэл тайланг ирүүлж хэвших
- Сүрьеэгийн асуумжит үзлэгт сэжигтэй тохиолдлын сорьц ирүүлэх, сар бүр хоёр сорьцыг тээвэрлэх, эрсдэлтэй хүн амын судалгаа гаргаж илрүүлэг үзлэгт хамруулахад санаачлагатай ажиллах

ХЯНАСАН:

ДҮГНЭЛТ ХИЙСЭН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ТҮВШИНБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН П.БАЯРМАА